

Эрхэм найзууд аа,

Тэнгэрлэг Эцэг бошиглогчдоороо дамжуулан бидэнтэй ярьдаг. Өнгөрсөн сард бид Ерөнхий чуулганаар бошиглогч, төлөөлөгчдийн үгийг сонссон! Чуулган дээр хэлсэн үгс бид бүгдэд чухал байдаг. Тэдгээр нь Есүс Христтэй хэрхэн илүү адилхан болох ёстойг хэлж өгдөг.

Чуулганы ямар хэсэг чамд таалагдсан бэ? Бошиглогчийн тусгай захиасыг уншихын тулд 2-р хуудсанд очно уу!

Хайртай шүү,
Найз



БИ ХЭН БЭ?

Бид “Би хэн бэ?” гэдэг тоглоом тоглож байна. Бидэнд таалагдсан шүү (2020 оны 6-р сар)! Зугаатай тоглоом тоглож, сайхан түүхүүд хуваалцсанд баярлалаа! Бид бас хоол идэж байхдаа *Найз* сэтгүүлийн аудио түүхүүдийг сонсох дуртай. Энэ нь Сүнсийг гэртээ мэдрэх боломж олгодог.

Валентина, Жулиа П. хоёр 4, 11 настай, АНУ-ын Аризона



БИ АРИУН СҮМ ХАРАХ ДУРТАЙ

6, 11 ба 3 настай Ларс, Марен, Ливиа нар Сэйнт Пол Миннесота ариун сүмд зочилсон.



БИД НАЙЗ СЭТГҮҮЛИЙГ ХААНА УНШДАГ ВЭ?

6 ба 3 настай ах дүү **Марсело, Алежандро А.** нар Мексикийн Нуэво Леонд *Найз* сэтгүүлийг испани хэл дээр уншдаг.